



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

80/4 оны 09 сарын 12 өдөр

Дугаар A/368

Улаанбаатар хот

**Тушаалд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжирааны зардлын зээл олгох журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” 2014 оны А/53 дугаар тушаалын хавсралтад байгаа “Мягмарсамбуу овогтой Гантулга АНУ-ын Калифорнийн их сургуулийн магистрын ургалтад мэдээллийн технологийн чиглэлээр 2 жил гэснийг” “Мягмарсамбуу овогтой Гантулга АНУ-ын Виржиниагийн олон улсын их сургуулийн магистрын сургалтад мэдээллийн технологийн чиглэлээр 2 жил” гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” 2012 оны А/348 дугаар тушаалын хавсралтад байгаа “Дорждагва овогтой Батгэрэл АНУ-ын Пасифик Стэтэс их сургуулийн магистрын сургалтад хэл шинжлэлийн чиглэлээр 2 жил” гэснийг “Дорждагва овогтой Батгэрэл АНУ-ын Дэ Паул их сургуулийн магистрын сургалтад хэл шинжлэлийн чиглэлээр 2 жил” гэж, “Пүрэвсүрэн овогтой Цэрэнчимэд БНСУ-ын Кён Хи их сургуулийн магистрын сургалтад био механикийн чиглэлээр 2 жил” гэснийг Пүрэвсүрэн овогтой Цэрэнчимэд БНСУ-ын Кён Хи их сургуулийн докторын сургалтад био механикийн чиглэлээр 3 жил” гэж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2014 оны А/291 дүгээр тушаалын Дамдиндорж овогтой Дэжидмаад холбогдох хэсгийн “1,5 жилийн хугацаатайгаар” гэснийг “2 жилийн хугацаатайгаар” гэж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай” 2012 оны А/67, Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2013 оны А/442 дугаар тушаалын Гэрэлчuluун овогтой Содгэрэлд холбогдох хэсгийг “Гэрэлчuluун овогтой Содгэрэл Ливерпуулийн их сургуульд иргэний инженерийн мэргэжлээр 4 жил” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.

Л.ГАНТӨМӨР

00/000/